



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/18

Улаанбаатар хот

Томиллолтоор ажиллуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/141 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. LB-1500 шинэ үйлдвэрийн тоног төхөөрөмжийг үр ашигтайгаар ажиллуулах шинэ санаачилга гаргасны дагуу материал, тоног төхөөрөмжийн судалгаа, сонголт хийх зорилгоор Үйлдвэрлэлийн баазын Асфальт бетон үйлдвэрийн Инженер Бадамдоржийн Отгонбаярыг гадаад улсад томиллолтоор ажиллуулсугай.

2. Томиллолтоор ажиллахад шаардагдах зардлыг 3 350 000 /Гурван сая гурван зуун тавин мянган/ төгрөгийг хавсралтаар баталж, албан томилолтын зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Томилолтын хугацаанд судалсан материал, тоног төхөөрөмжийг баримтжуулан, тайлангаа ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Асфальт бетон үйлдвэрийн Инженер Б.Отгонбаярт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /М.Зундуйдаваа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН